



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН Ч ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ САНГИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл	6
Бүлэг1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА	7
1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна	7
1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?	7
1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримталж хуваарилж олгосон байна	7
1.1.3 Сангийн яамнаас 151.8 сая төгрөгөөр санхүүжилт дутуу ирснээс шалтгаалан аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваариас бууруулан олгосон байна.	8
1.1.4 Сумдын ОНХС-д ОНХНС-аас хуваарилснаас гадна 2,204.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.	10
1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан ч, Бөхмөрөн, Наранбулаг сум иргэдийн санал аваагүй байна	12
1.2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Бөхмөрөн, Наранбулаг сум иргэдээс санал аваагүй байна	12
1.2.2 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна	13
1.2.3 Төсвийн тухай хуульд заасан шаардлага шалгуур хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна	15
1.2.4 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 14.8 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг Наранбулаг, Тариалан, Хяргас сумд тусгасан байна	16
Бүлэг2 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	19
2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан ч бодит гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 1 төсөл, арга хэмжээнд 128.0 сая, зориулалт бусаар 2 төсөл, арга хэмжээнд 7.0 сая төгрөгийг зарцуулсан байна	19
2.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна	19
2.1.2 ОНХС-ийн хөрөнгөөс бодит гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 1 төсөл, арга хэмжээнд 128.0 сая, зориулалт бусаар 2 төсөл, арга хэмжээнд 7.0 сая төгрөгийг зарцуулсан байна	24
2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх боломж байна	26
2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 39 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнд хүрээгүй, 2 төсөл, арга хэмжээ хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна	26
2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь орон	30

	нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөө багатай байна	
2.3	ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна	31
2.3.1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна	31
2.3.2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна	33
Бүлэг3	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН ТАЙЛАГНААГҮЙ, ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	34
3.1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна	34
3.1.1	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, аймаг, сумдын ИТХ-ын хяналт хангалтгүй байна	34
3.1.2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар гэрээний дагуу хэрэгжүүлж байна	35
3.1.3	Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна	36
3.2	ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаагүй, удирдлага мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулаагүй байна	38
3.2.1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлээгүй байна	38
3.2.2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан ч 1 төсөл, арга хэмжээг буруу дүнгээр бүртгэсэн байна.	38
3.2.3	Сангийн хөрөнгийн зарцуулалтад, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд зарим сум оруулаагүй, зарим сум дутуу оруулсан байна	39
3.2.4	ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь мэдээлсэн байна	41
Дүгнэлт		42
Холбогдох байгууллагын санал		43-46
Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар		47
Зөвлөмж		48

Товчилсон үгийн тайлбар

ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ШША	Шүүх шинжилгээний алба
ХО	Хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТНХ	Түмэнд нээлттэй хязгаарынхан
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
УМС	Удирдлага мэдээллийн систем
АМХТЗТ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр
АМАТЗТ	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
УМС	Удирдлага мэдээллийн систем
ОБГ	Онцгой байдлын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	ОНХС-ийн 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт	6
2	ОНХС-ийн 2023 оны тодотгосон төсөв	7
3	ОНХС-ийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөлт	8
4	Аймаг сумдын ОНХС-д олгох орлогын хуваарилалт	9
5	Аймаг сумдын ОНХС-д олгосон санхүүжилт	9-10
6	Аймаг сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө	11
7	Аймаг сумдын ОНХС-д нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	12
8	Аймаг сумдын ОНХС-р батлагдсан төсөл арга хэмжээ	14
9	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээ, бодлогын баримт бичгийн уялдаа	14
10	Аймгийн ОНХС-ийн 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чиг үүргийн нийцэл	17
11	Сумдын ОНХС-ийн 2023 онд хэрэгжүүлсэн чиг үүрэгт нийцээгүй арга хэмжээ	18
12	Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт	20-21
13	ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт	22
14	ОНХС-ийн 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт	24
15	ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хийгдсэн ажил	25
16	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хийгдсэн ажил	27
17	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хийгдсэн ажил	28-29
18	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ	30
19	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хөрөнгийн ашиглалт	32
20	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	36-38
21	УМС-д мэдээлсэн төсөл арга хэмжээ	40

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулсан.*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны Засаг дарга, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд ахлах аудитор Т.Намжил, аудитор Т.Амармэнд, Б.Нямбуу нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрт тусгагдсан цаглаварт хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах төлөвлөгөөт аудитууд зэрэг хийгдсэнээс шалтгаалан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн

төсөл, арга хэмжээ бүрийг газар дээр нь очиж үзэж амжаагүй болно. Аудитын хүрээнд Улаангом сум болон хөдөөгийн 5 суманд очиж ажилласан бөгөөд бусад сумдад хийгдсэн төсөл, арга хэмжээний баримт материалыг татан авч, шаардлагатай тохиолдолд зөрчлийн тэмдэглэл үйлдэн тулган баримтжууллаа.

Аудитын дүн

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 2 санал хүргүүлсэн болно.

Сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар ОНХС-тай холбоотой илэрсэн зөрчилд 10 зөвлөмж, 1 албан шаардлага өгч, 2 залруулга хийлгэснийг энэхүү аудитын тайланд зөрчлөөр давтан тусгаагүй бөгөөд өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийн хэсэгт тусгасан болно.

Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлээр ОНХС болон улсын төсвөөс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 9,096.3 сая төгрөгөөр баталсан ба 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2,227.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 11,324.0 сая төгрөгөөр баталсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 10,931.3 сая төгрөг, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 392.7 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймгийн хэмжээнд 506 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр 14,093.0 сая төгрөгийг баталснаас 9,166.6 сая төгрөгийн 408 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1,371.7 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй буюу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 73.6 хувьтай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт Хүснэгт 1. (сая төгрөг)

№	Аймаг, Сум	Тоо	Төсөвт өртөг	Бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний		Дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний		Хэрэгжээгүй төсөл арга хэмжээний		Хэрэгжилт (хувь)
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Баруунтуруун	20	378.6	15	194.5	3	90.3	2	74.0	75.2
2	Бөхмөрөн	12	284.4	11	233.2			1	45.0	82.0
3	Давст	18	344.2	15	239.3	2	5.5	1	91.0	71.1
4	Завхан	22	507.4	19	293.0	1	3.0	2	41.1	58.3
5	Зүүнговь	27	413.3	15	156.0	6	65.0	6	108.8	53.5
6	Зүүнхангай	22	474.9	20	409.8			2	59.5	86.3
7	Малчин	36	405.4	33	372.1	1	10.0	2	10.1	94.3
8	Наранбулаг	29	638.5	25	431.6	1	113.8	2	41.0	85.4
9	Өлгийн	17	222.7	14	147.7	2	30.0	1	9.2	79.8
10	Өмнөговь	30	517.6	25	428.4	1	19.9	4	49.0	77.8
11	Өндөрхангай	23	707.0	12	385.4	3	85.4	7	195.0	64.7
12	Сагил	20	388.2	13	263.4	2	0.0	5	95.0	67.9
13	Тариалан	22	435.7	15	210.9	2	74.9	5	74.1	65.6
14	Түргэн	12	231.7	9	117.2	1	56.0	2	24.3	74.8
15	Тэс	20	582.1	17	288.2	2	90.4	3	154.2	65
16	Ховд	14	305.5	12	202.3			2	100.0	66.2
17	Хяргас	19	300.1	15	198.8	2	31.4	2	51.0	76.7
18	Цагаанхайрхан	29	416.3	19	266.0	5	77.8	5	17.5	82.6
19	Улаангом	78	1,073.6	75	1,017.6	1	2.1	2	32.0	97.8
20	Аймгийн ОНХС	36	5,465.7	29	3,311.2	6	477.5	1	100.0	69.3
Нийт дүн		506	14,093.0	408	9,166.6	41	1,232.9	57	1,371.7	73.6

Эх сурвалж: Аймаг, сумдаас ирүүлсэн судалгаа

БҮЛЭГ 1

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ
ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ,
ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?

Орон нутагт хамаарахгүй.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримталж хуваарилж олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно”, 59.3.1 дэх заалтад “орон нутгийн хөгжлийн индекс”, 59.3.2 дахь заалтад “хүн амын тоо”, 59.3.3 дахь заалтад “нутаг дэвсгэрийн хэмжээ” гэж заасны дагуу ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилж олгосон байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд ОНХНС-аас 9,096.3 сая төгрөгийн санхүүжилт баталсныг тодотгол хийж 11,324.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2023 оны төсөвт тодотгол хийсэн дүнгээр харуулбал.

Хүснэгт 2.

(сая төгрөг)

Аймаг	Итгэлцүүрээр хуваарилагдах дүн	АМХТЗТ	АМАТЗТ	Урамшуулал	Нийт
Увс	10,422.0	331.8	177.5	392.7	11,324.0

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс /

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө”, 6.2 дахь хэсэгт “Сум, дүүргийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө” гэж заасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн орлогыг дэмжих зорилгоор авах дотоод, гадаадын хандив тусламж

Дээрх журамд заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

Ингэхдээ ОНХНС-аас олгохоор баталсан санхүүжилтийг аймгийн ИТХ-ын

2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор 2023 онд аймгийн ОНХС-д 4,351.8 сая, сумдын ОНХС-д 4,744.5 сая, нийт 9,096.3 сая төгрөгийг олгохоор анх баталсныг аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж аймгийн ОНХС-д 5,465.7 сая, сумдын ОНХС-д 5,858.3 сая, нийт 11,324.0 сая төгрөг олгохоор баталж, гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д 5,399.0 сая, сумдын ОНХС-д 5,706.5 сая, нийт 11,105.5 сая төгрөгийг олгосон байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, тогтоомжид заасны дагуу дараах байдлаар төлөвлөж бүрдүүлсэн байна.

Хүснэгт 3.

(сая төгрөг)

№	Орлогын нэр төрөл	Аймаг		Сум	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	ОНХНС	5,465.7	5,399.0	5,858.3	5,706.5
2	Олон улсын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэг, урамшуулал			4.0	4.0
3	Үйл ажиллагааны орлого				
4	Өмнөх оны үлдэгдэл			1,163.9	776.9
5	Бусад орлого			442.6	550.0
6	Малын тоо толгойн албан татвар			1,158.5	873.1
	Нийт дүн	5,465.7	5,399.0	8,627.3	7,910.5

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн алба/

Хүснэгтээс харахад аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-ийн эх үүсвэрт 14,093.0 сая төгрөг төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 13,309.5 сая төгрөг олгосон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 11,324.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөн баталсан ч гүйцэтгэлээр 11,105.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.3. Сангийн яамнаас 151.8 сая төгрөгөөр санхүүжилт дутуу ирснээс шалтгаалан аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваариас бууруулан олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дэх хэсэгт “Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна” гэж заажээ. Үүнд:

- Энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;
- Улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6-д зааснаар хуваарилах.
- Энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуульд заасны дагуу хуваарилсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4.

(сая төгрөг)

№	Үзүүлэлт Сумдууд	Нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах		Хүн амын тооноос хамаарах		Алслалтаас хамаарах		Итгэлдүүрээр хуваарилагдсан нийт дүн	Урамшуулал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /сумдал хуваарилах суурь 50 хувь/	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр /сумдал хуваарилах суурь 50 хувь/	2023 онд олгохоор төлөвлөсөн санхүүжилт	2023 онд олгосон санхүүжилт
		Нутаг дэвсгэрийн хэмжээ /мян.км2/	Нутаг дэвсгэрээс хамаарах хуваарилалт 30%	Хүн амын тоо	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 40%	Аймаг хүргэлх зай /км/ 30%	Алслалтаас хамаарах хуваарилалт 30%						
1	Баруунтуруун	3,300	74.1	2,802	68.5	193	111.2	253.7	36.3	-	-	290.0	282.6
2	Бөхмөрөн	3,700	83.1	2,294	56.0	174	82.1	221.2		10.4	7.8	239.4	233.3
3	Давст	6,300	141.4	1,592	38.9	136	44.5	224.9	33.6	2.2	0.4	261.1	254.4
4	Завхан	6,800	152.7	1,913	46.7	161	63.3	262.7		2.4	2.1	267.3	260.4
5	Зүүнговь	4,000	89.8	2,895	70.7	139	82.7	243.3	34.8	-	-	278.0	270.9
6	Зүүнхангай	2,600	58.4	2,409	58.9	357	176.8	294.1		-	0.3	294.4	286.8
7	Малчин	4,000	89.8	2,472	60.4	99	50.3	200.5	29.5	22.8	-	252.8	246.3
8	Наранбулаг	5,300	119.0	4,400	107.5	90	81.4	307.9		37.6	53.5	399.0	388.8
9	Өлгий	2,300	51.6	2,493	60.9	113	57.9	170.5		36.5	-	207.0	201.7
10	Өмнөговь	3,200	71.8	4,772	116.6	109	107.0	295.4	42.5	13.1	1.2	352.2	343.1
11	Өндөрхангай	4,700	105.5	3,238	79.1	286	190.4	375.1		7.4	-	382.5	372.6
12	Сагил	3,800	85.3	2,507	61.3	61	31.4	178.0		4.1	0.8	182.9	178.2
13	Тариалан	3,800	85.3	4,067	99.4	30	25.1	209.8	36.8	10.2	8.8	265.6	258.7
14	Түргэн	2,300	51.6	2,100	51.3	36	15.5	118.5		0.7	7.5	126.7	123.4
15	Тэс	3,100	69.6	5,211	127.3	155	166.1	363.0		-	-	363.0	353.7
16	Улаангом	30	0.7	32,912	804.1	0	-	804.8	112.9	4.9	0.1	922.7	896.7
17	Ховд	3,000	67.4	2,555	62.4	177	93.0	222.8	31.8	-	-	254.6	248.0
18	Хяргас	3,400	76.3	2,564	62.6	163	85.9	224.9		8.9	5.3	239.1	232.9
19	Цагаанхайрхан	4,000	89.8	2,118	51.7	226	98.4	240.0	34.6	4.6	0.8	280.0	273.8
		69,630	1,563.3	85,314	2,084.4	2,705	1,563.3	5,211.0	392.7	165.9	88.8	5,858.3	5,706.5

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 8.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т зааснаас доошгүй хувь хэмжээгээр сум дүүргийн ОНХС-д хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1 болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилагдсан сум, дүүргийг мөн багтаан тооцно” гэж заасны дагуу ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сумдын ОНХС-д хуваарилахдаа алслалт болон газар нутгийн хэмжээнээс тус бүр 30 хувь, хүн амын тооноос 40 хувиар хамааруулж тооцсон байна.

Сумдад олгохоор төлөвлөсөн санхүүжилт Сангийн яамнаас 151.8 сая төгрөгөөр дутуу ирснээс шалтгаалан сум бүрд тодорхой хэмжээгээр бууруулан хуваарилж олгосон байна. Үүнээс шалтгаалан тухайн жилийн Төсвийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй, төлөвлөсөн ажил гүйцэт хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж байгаа тул УАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

Сумдын ОНХС-д олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 5.

(сая төгрөг)

ОНХНС-аас олгосон санхүүжилт					
№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Батлагдсан дүн /тодотголоор/	олгосон санхүүжилт	Зөрүү	Ирсэн санхүү- жилтийн хувь
1	Баруунтуруун	290.0	282.6	7.4	97.4
2	Бөхмөрөн	239.4	233.3	6.1	97.4
3	Давст	261.1	254.4	6.7	97.4
4	Завхан	267.3	260.4	6.9	97.4
5	Зүүнговь	278.0	270.9	7.1	97.4
6	Зүүнхангай	294.4	286.8	7.6	97.4

7	Малчин	252.8	246.3	6.5	97.4
8	Наранбулаг	399.0	388.8	10.2	97.4
9	Өлгий	207.0	201.7	5.3	97.4
10	Өмнөговь	352.2	343.2	9.0	97.4
11	Өндөрхангай	382.5	372.6	9.9	97.4
12	Сагил	182.9	178.2	4.7	97.4
13	Тариалан	265.6	258.7	6.9	97.4
14	Түргэн	126.7	123.5	3.2	97.4
15	Тэс	363.0	353.7	9.3	97.4
16	Улаангом	922.7	896.7	26.0	97.2
17	Ховд	254.6	248.0	6.6	97.4
18	Хяргас	239.1	232.9	6.2	97.4
19	Цагаанхайрхан	280.0	273.8	6.2	97.8
	Сумдын дүн	5,858.3	5,706.5	151.8	

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.9-д “ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй” гэж заасныг мөрдөж ажилласан байна.

1.1.4. Сумдын ОНХС-д ОНХНС-аас хуваарилснаас гадна 2,204.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “ОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заажээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь;
- Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг

нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна;

- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж;
- Энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6.

(сая төгрөг)

№	Сумын нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХС-аас батлагдсан дүн /тодотголоор/	Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад орлого	Малын тоо толгойн татвар	Нийт
1	Аймаг		5,465.7			5,465.7
2	Баруунтуруун	34.6	290.0	-	54.0	378.6
3	Бөхмөрөн	8.0	239.4	-	37.0	284.4
4	Давст	60.4	261.1	-	22.8	344.3
5	Завхан	24.3	267.3	157.5	58.3	507.4
6	Зүүнговь	115.3	278.0	-	20.0	413.3
7	Зүүнхангай	63.9	294.4	57.2	59.5	475.0
8	Малчин	34.5	252.8	20.0	98.0	405.3
9	Наранбулаг	168.5	399.0	36.0	35.0	638.5
10	Өлгий		207.0	-	15.7	222.7
11	Өмнөговь	9.1	352.2	42.0	114.2	517.5
12	Өндөрхангай	161.6	382.5	38.0	125.0	707.1
13	Сагил	65.3	182.9	50.0	90.0	388.2
14	Тариалан	81.1	265.6	4.0	85.0	435.7
15	Түргэн	85.0	126.7	-	20.0	231.7
16	Тэс	104.6	363.0	-	114.5	582.1
17	Ховд	17.0	254.6	-	33.9	305.5
18	Хяргас	5.0	239.1	11.0	45.0	300.1
19	Цагаанхайрхан	80.7	280.0	-	55.5	416.2
20	Улаангом	45.0	922.7	30.8	75.0	1,073.5
	Сумдын дүн	1,163.9	5,858.3	446.6	1,158.5	8,627.4
	Аймаг, сумдын дүн		11,324.0			14,093.0

Эх сурвалж: /Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд/

Аймгийн Орон нутгийн хөгжлийн санд дээрх хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж нэмж төлөвлөсөн эх үүсвэр байхгүй байна.

Харин сумдын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийн хүрээнд нийт 2,769.0 сая төгрөгийн санхүүжилт оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2,204.0 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн байна.

Сумдын Орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 7.

(сая төгрөг)

№	Сумын нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл		Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад орлого		Малын тоо толгойн татвар	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баруунтуруун	34.6	34.6	-	12.7	54.0	37.1
2	Бөхмөрөн	8.0	8.0	-	22.4	37.0	12.3
3	Давст	60.4	-	-	41.9	22.8	28.5
4	Завхан	24.3	24.3	157.5	9.0	58.3	52.9
5	Зүүнговь	115.3	115.3	-	60.5	20.0	32.5
6	Зүүнхангай	63.9	-	57.2	19.5	59.5	52.0
7	Малчин	34.5	34.5	20.0	32.4	98.0	106.8
8	Наранбулаг	168.5	109.1	36.0	-	35.0	29.6
9	Өлгий		-	-	8.3	15.7	15.7
10	Өмнөговь	9.1	9.1	42.0	71.1	114.2	46.3
11	Өндөрхангай	161.6	60.4	38.0	35.7	125.0	101.8
12	Сагил	65.3	69.1	50.0	132.5	90.0	83.1
13	Тариалан	81.1	81.1	4.0	12.6	85.0	72.5
14	Түргэн	85.0	85.0	-	1.0	20.0	-
15	Тэс	104.6	-	-	15.0	114.5	16.2
16	Ховд	17.0	29.8	-	35.9	33.9	33.9
17	Хяргас	5.0	3.6	11.0	10.7	45.0	45.0
18	Цагаанхайрхан	80.7	72.6	-	32.9	55.5	32.0
19	Улаангом	45.0	40.5	30.8	12.7	75.0	75.0
	Дүн	1,163.9	776.9	446.6	554.0	1,158.5	873.1

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Түүнчлэн зарим сумдын Орон нутгийн хөгжлийн санд нийт 2,204.0 сая төгрөгийн өвс, тэжээлийн үнэ болон бусад орлого төвлөрүүлсэн байна.

1.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан ч, Бөхмөрөн, Наранбулаг сум иргэдийн санал аваагүй байна.

1.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Бөхмөрөн, Наранбулаг сум иргэдээс санал аваагүй байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”, Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.3-д “Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална”, 6.3.5-д “Иргэдийн оролцоог хангасан байх”, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, агентлаг,

шат шатны ИТХ, төсвийн захирагчид, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн саналыг албан бичгээр авч эрэмбэлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн нийт 5,465.7 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин Бөхмөрөн сум 284.4 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг, Наранбулаг сум 638.5 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээг тус тус Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлахдаа иргэдээс санал аваагүй байна.

Цаашид орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлахгүй байхыг зөвлөмж болгов.

Бусад сумдын хувьд Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн тэмдэглэл хөтөлж сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна. Сумдын Засаг даргын Тамгын газар тухайн төсөл, арга хэмжээнүүдийг ач холбогдол, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд уялдуулан эрэмбэлж ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдаагүй Нэгдүгээр сургуулийн ухаалаг самбар худалдан авах ажилд 25.9 сая зарцуулсанд Тэс сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталж байх зөвлөмж өгсөн.

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.1-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасан байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 506 төсөл, арга хэмжээг 14,093.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 8.

(сая төгрөг)

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээний	
		тоо	мөнгөн дүн
1	Баруунтуруун	20	378.6
2	Бөхмөрөн	12	284.4
3	Давст	18	344.2

4	Завхан	22	507.4
5	Зүүнговь	27	413.3
6	Зүүнхангай	22	474.9
7	Малчин	36	405.4
8	Наранбулаг	29	638.5
9	Өлгийн	17	222.7
10	Өмнөговь	30	517.6
11	Өндөрхангай	23	707.0
12	Сагил	20	388.2
13	Тариалан	22	435.7
14	Түргэн	12	231.7
15	Тэс	20	582.1
16	Ховд	14	305.5
17	Хяргас	19	300.1
18	Цагаанхайрхан	29	416.3
19	Улаангом	78	1,073.6
20	Аймгийн ОНХС	36	5,465.7
Нийт дүн		506	14,093.0

Эх сурвалж: /Сумын ИТХ-ын тогтоолууд/

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 5,465.7 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 9.

Д/д	Бодлогын баримт бичиг	Бүлгийн агуулга
1	Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	Хүний хөгжлийн бодлого
		Эдийн засгийн бодлого
		Засаглалын бодлого
		Ногоон хөгжлийн бодлого
		Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого
2	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 8 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	Үндэсний нэгдмэл үнэт зүйл
		Хүний хөгжил
		Амьдралын чанар ба дундаж давхарга
		Эдийн засаг
		Засаглал
		Ногоон хөгжил
		Амар тайван, аюулгүй нийгэм
		Бүс, сум, орон нутгийн хөгжил

Түүнчлэн Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулсан байна.

1.2.3. Төсвийн тухай хуульд заасан шаардлага шалгуур хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.3 дахь заалтад “Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 6.2.6 дахь заалтад “Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар бол доор дурдсан зохицуулалт хийнэ”, 6.2.6.а-д “Тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсөв батлахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4,351.8 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийж Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5,465.7 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг баталсан байна. Тодотголоор анх баталсан төсөл, арга хэмжээнээс 773.5 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг хасаж, 1,967.4 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна. Үүнд:

Хасагдсан төсөл, арга, хэмжээний хувьд:

1. Чацарганын үйлдвэрийн тоног төхөөрөмж 773.5 сая,

Нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний хувьд:

1. 9-р цэцэрлэгийн засвар, шинэчлэл 226.4 сая /Улаангом сум/
2. Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж 100.0 сая /Сагил сум/
3. Аймгийн Засаг даргын тамгын газрын зураг төсөв 180.0 сая /Улаангом сум/
4. 1, 2, 3 дугаар 12 айлын хэсэгчилсэн дахин төлөвлөлтийн барилгын буулгалтын зардал 100.0 сая /Улаангом сум, 11-р баг /
5. Мал угаалгын ванны засвар, шинэчлэл 10.0 сая /Бөхмөрөн сум Хар-Алтат баг/
6. Ундны усны автомашин 85.0 сая /Өлгий сум/
7. Багийн эмчийг унаажуулах 12.0 сая /Хяргас сум/
8. Айл өрхийг цэвэр усны ухаалаг тоолуураар хангах 60.0 сая /Улаангом сум/
9. Терроризмтой тэмцэх зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл 18.0 сая /Тагнуулын газар/
10. Нийгмийн даатгалын 13400 тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах программ хангамж 7.5 сая /Нийгмийн даатгалын хэлтэс/
11. Зураг төсөв боловсруулах, магадлал хийлгэх, геологийн судалгааны зардал 249.1 сая
12. Хүүхдийн эрх, хөгжлийг дэмжих өрөөний тохижилт 10.0 сая /Прокурорын газар/
13. Хүүхдийн эрх, хөгжлийг дэмжих өрөөний тохижилт 5.0 сая /Шүүхийн тамгын газар/
14. Цагдан хорих байрны теле хяналтын тоног төхөөрөмж 5.0 сая /ШШГГ/
15. Эрэн хайх, аврах ажиллагааны холбоо сүлжээний станц 20.0 сая /ОБГ/
16. 3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар -"ТНХ" ХХК- ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл үргэлжлэл 494.0 сая /Увс, Улаангом сум/
17. "Загвар хоршоодын хөгжлийг дэмжих төв" -ийн зөвлөх үйлчилгээ 60.0 сая

18. 1, 2-р 48 айлын орон сууцны зоорийн давхрын шугам сүлжээний засвар 283.0 сая /Улаангом сум/
19. Зарим төрийн байгууллагад дулааны тоолуур худалдан авах 48.8 сая
20. Сумын төвийн тохижилтын ажлын санхүүжилтийн дутуу 13.9 сая /Өлгий сум/

Мөн төсвийн тодотгол хийхээс өмнө тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 9 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг гэрээний дүнгээр болгон анхны төсөвт өртгийг 100.4 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дэх хэсэгт “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ”, тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна”, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх” гэж заасан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл шаардлагатай 13 төсөл, арга хэмжээ нь зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлтэй байна. Харин аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөвт өртөг багатай төсөл, арга хэмжээнүүдийн хувьд ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үндэслэн төлөвлөсөн байна.

1.2.4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 14.8 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг Наранбулаг, Тариалан, Хяргас сумд тусгасан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-д “Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;
- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;
- Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх;
- Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
- Ажлын байр бий болгох.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх 36 төсөл, арга хэмжээний хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт дараах байдлаар нийцэж байна.

Хүснэгт 10.

(сая төгрөг)

№	Шалгуур үзүүлэлт	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи	14	825.9
2	Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	10	3,506
3	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	4	299.6
4	Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах	2	145.0
5	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах	4	579.4
6	Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	2	110.0
Нийт дүн		36	5,465.7

Эх сурвалж: /Аймгийн ОНХС-ийн нэгтгэл судалгаа/

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 4.4-д “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;
- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;
- Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
- Ажлын байр бий болгох;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 4.5-д “Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- Бэлчээрийн менежментийг сайжруулах;
- Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/
- Малын эрүүл мэндийг хамгаалах;
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- Малын чанарыг сайжруулах;
- Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
- Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
- Малын тэжээлийн ургамал тариалах;
- Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах;
- Хортон мэрэгчидтэй тэмцэх /байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;
- Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа гэж заажээ.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх 470 төсөл, арга хэмжээнээс 466 төсөл, арга хэмжээний хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэж байна.

Харин дараах 4 төсөл, арга хэмжээний хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэхгүй байна.

Хүснэгт 11.

(сая төгрөг)

№	Сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гүйцэтгэл
1	Наранбулаг	ИТХ-ын төлөөлөгчдийг чадвахжуулах сургалт	5.8	5.8
2	Наранбулаг	Багийн дарга нарын ажилд дэмжлэг үзүүлэх	2.0	2.0
3	Тариалан	П.Сайнжаргалын оюутны төлбөр	4.0	4.0
4	Хяргас	Сумын эрүүл мэндийн төвийн эмчийг урамшуулах,сургахад	3.0	3.0
	Нийт		14.8	14.8

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцэхгүй дээрх 4 төсөл, арга хэмжээнд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан шаардлага өгсөн болно.

БҮЛЭГ 2

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан ч бодит гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 1 төсөл, арга хэмжээнд 128.0 сая, зориулалт бусаар 2 төсөл, арга хэмжээнд 7.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Мөн Засаг даргын захирамжаар сумдад болон төсөвт байгууллагуудад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороог байгуулан ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Мөн Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг дараах байдлаар шилжүүлж болно”, 4.1.1-д “Төсвийн тухай хуулийн 14.4-д заасныг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн төвлөрүүлэн захирагчид, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг шилжүүлэх”, 4.1.2-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх” гэж заажээ.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих 33 төсөл, арга хэмжээнээс 9 төсөл, арга хэмжээний эрхийг тайлант онд харьяалах төсвийн захирагч нарт шилжүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр захирамжаар 3 төсөл, арга хэмжээг:

1. Газрын хэмжилт, хянан баталгааны тоног төхөөрөмж /ГХБХБГ/
2. Лабораторийн тоног төхөөрөмж /Шүүх шинжилгээний алба/
3. Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах /Өндөрхангай сум/

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/462 дугаар захирамжаар 6 төсөл, арга хэмжээг:

1. Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж /Сагил сум/
2. Терроризмтой тэмцэх зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Тагнуулын газар/
3. Нийгмийн даатгалын 13400 тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах программ хангамж /Нийгмийн даатгалын хэлтэс/
4. Хүүхдийн эрх, хөгжлийг дэмжих өрөөний тохижилт /Прокурорын газар/
5. Хүүхдийн эрх, хөгжлийг дэмжих өрөөний тохижилт /Шүүхийн тамгын газар/
6. Цагдан хорих байрны теле хяналтын тоног төхөөрөмж /ШШГГ/

Орон нутгийн өмчийн газар аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 19 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж 1 төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг захиалагч ирүүлээгүй хугацаа алдсанаас худалдан авах ажиллагааг зарлаагүй байна.

Худалдан авах ажиллагааг явуулахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газраас 3 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын арга, 16 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргыг ашигласан байна. Мөн аймгийн ЗДТГ-аас шууд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 4 төсөл, арга хэмжээ байна.

Эрх шилжүүлсэн 9 төсөл, арга хэмжээний хувьд дараах аргуудыг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

- Харьцуулалтын арга - 3
- Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын арга – 1
- Шууд худалдан авалтын арга - 5

ОНХС-ийн хөрөнгөөр зохион байгуулсан худалдан авах ажиллагаа дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 12.

(сая төгрөг)

Д/Д	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан Байгууллагын нэр	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг (сая.төг)	Эрх шилжүүлсэн эсэх	Гэрээний дүн (сая.төг)	Санхүүжилтийн дүн (сая.төг)	ХАА-нд мөрдсөн журам
1	ОНӨГ ХХА	Хөгжлийн ирээдүйтэй суурин техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, /Тариалан сум, Хөх үхэртийн гэрсэн, Адаргана, Зүүнхангай сум, Далантүрүү баг /	90.2	Үгүй	90.2	90.2	НТШ
2	ОНӨГ ХХА	"Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/	117.0	Үгүй	117.0	116.2	НТШ
3	ОНӨГ ХХА	Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/	256.0	Үгүй	256.0	128.0	НТШ
4	ОНӨГ ХХА	Улаангом сумын зүүн тойргийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг эхлүүлэх	900.0	Үгүй	889.9	250.0	НТШ
5	ОНӨГ ХХА	Багц 1: Сумын төвийн тохижилт /Өмнөговь сум / 90 сая	145.1	Үгүй	88.2	88.2	НТШ
	ОНӨГ ХХА	Багц 2: Хог тээвэрлэх автомашин /Өмнөговь сум/ 60 сая		Үгүй	57.0	57.0	
6	ОНӨГ	ЕБС -ийн цахим сургалтын тоног төхөөрөмж /19	94.3	Үгүй	94.3	94.3	НТШ

	ХХА	сумын ЕБС/					
7	ОНӨГ ХХА	Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг /Улаангом сум, 10 дугаар баг /	150.0	Үгүй	149.8	149.8	НТШ
8	ОНӨГ ХХА	Гэр хорооллын гэрэлтүүлэг /Улаангом сум, 1 дүгээр баг/	233.9	Үгүй	233.9	233.9	НТШ
9	ОНӨГ ХХА	Хуучин нисэхийн талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний инженерийн дэд бүтцийн ажил /Улаангом сум, 5 дугаар баг, Түмэндэлгэржав хороолол/	614.9	Үгүй	614.9	614.9	НТШ
10	ОНӨГ ХХА	Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил /Улаангом сум/	595.5	Үгүй	595.5	595.5	НТШ
11	ОНӨГ ХХА	9-р цэцэрлэгийн засвар, шинэчлэл /Улаангом сум/	226.4	Үгүй	220.8	220.8	НТШ
12	ОНӨГ ХХА	Аймгийн Засаг даргын тамгын газрын зураг төсөв /Улаангом сум/	180.0	Үгүй	169.0	0.0	НТШ
13	ОНӨГ ХХА	Ундны усны автомашин /Өлгий сум/	85.0	Үгүй	84.5	84.5	НТШ
14	ОНӨГ ХХА	Айл өрхийг цэвэр усны ухаалаг тоолуураар хангах /Улаангом сум/	60.0	Үгүй	59.8	59.8	ХА
15	ОНӨГ ХХА	7-р багийн гэрэлтүүлгийн засвар, шинэчлэл /Улаангом/	93.5	Үгүй	93.5	93.5	НТШ
16	ОНӨГ ХХА	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар -"ТНХ" ХХК- ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл үргэлжлэл /Увс, Улаангом сум/	494.0	Үгүй	493.1	0.0	НТШ
17	ОНӨГ ХХА	"Загвар хоршоодын хөгжлийг дэмжих төв" -ийн зөвлөх үйлчилгээ	60.0	Үгүй	55.0	0.0	ХА
18	ОНӨГ ХХА	1, 2-р 48 айлын орон сууцны зоорины давхрын шугам сүлжээний засвар /Улаангом сум/	283.0	Үгүй	279.0	279.0	НТШ
19	ОНӨГ ХХА	Зарим төрийн байгууллагад дулааны тоолуур худалдан авах	48.8	Үгүй	48.5	48.5	ХА
20	АЗДТГ	Мал угаалгын ванны засвар, шинэчлэл /Бөхмөрөн сум Хар-Алтат баг/	10.0	Үгүй	10.0	10.0	ШХА
21	АЗДТГ	Багийн эмчийг унаажуулах /Хяргас сум/	12.0	Үгүй	12.0	12.0	ШХА
22	АЗДТГ	Эрэн хайх, аврах ажиллагааны холбоо сүлжээний станц /ОБГ/	20.0	Үгүй	20.0	20.0	ШХА
23	АЗДТГ	Зураг төсөв боловсруулах, магадлал хийлгэх, геологийн судалгааны зардал	249.1	Үгүй	187.9	187.9	ШХА
24	Прокурорын газар	Хүүхдийн эрх, хөгжлийг дэмжих өрөөний тохижилт /Прокурорын газар/	10.0	Тийм	10.0	10.0	ШХА
25	Шүүхийн тамгын газар	Хүүхдийн эрх, хөгжлийг дэмжих өрөөний тохижилт /Шүүхийн тамгын газар/	5.0	Тийм	5.0	5.0	ШХА
26	ШШГГ	Цагдан хорих байрны теле хяналтын тоног төхөөрөмж /ШШГГ/	5.0	Тийм	5.0	5.0	ШХА
27	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын 13400 тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах программ хангамж /Нийгмийн даатгалын хэлтэс/	7.5	Тийм	7.5	7.5	ШХА
28	Тагнуулын газар	Терроризмтэй тэмцэх зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Тагнуулын газар/	18.0	Тийм	18.0	18.0	ШХА
29	Сагил сум	Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж /Сагил сум/	100.0	Тийм	100.0	0.0	НТШ
30	Өндөрхангай сум	Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах /Өндөрхангай сум /	60.0	Тийм	54.0	54.0	ХА
31	ШША	Лобароторийн тоног төхөөрөмж /Шүүх шинжилгээний алба/	18.0	Тийм	18.0	18.0	ХА
32	ГХБХБГ	Газрын хэмжилт, хянан баталгааны тоног төхөөрөмж /ГХБХБГ/	44.9	Тийм	25.0 19.9	25.0 19.9	ХА
Нийт дүн			5,287.2		5,182.2	3,596.4	

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар/

Тухайн үед мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу дараах 2 төсөл, арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/ – 256.0 сая,
- Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг /Улаангом сум, 10 дугаар баг /- 150.0 сая

Захиалагч тендерийн баримт бичиг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг ирүүлээгүй нэг төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Үүнд:

- 1, 2, 3 дугаар 12 айлын хэсэгчилсэн дахин төлөвлөлтийн барилгын буулгалтын зардал /Улаангом сум, 11-р баг / -100.0 сая

Увс аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 13.

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Тайлант жилд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ТАХ-ний		Үүнээс										Олон нийтийн оролцоотой худалдан авалт	
				Нээлттэй тендер шалгаруулалт		Онцгой журам									
						Хязгаарлагдмал тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Баруунтуруун	18	304.6					2	100.0	16	204.6				
2	Бөхмөрөн	11	239.4	1	100.0			2	65.4	8	74.0				
3	Давст	13	317.9	1	91.0			4	128.0	9	98.9				
4	Завхан	21	496.3					4	187.2	17	309.1				
5	Зүүнговь	18	265.9					2	67.0	16	198.9				
6	Зүүнхангай	17	391.1					5	234.0	12	157.1				
7	Малчин	32	383.7					4	189.9	28	193.9				
8	Наранбулаг	22	551.5	2	200.0			4	160.2	16	191.3				
9	Өлгий	16	213.5					3	108.5	13	105.0				
10	Өмнөговь	25	476.3	1	120.0			5	165.0	19	191.3				
11	Өндөрхангай	16	562.0	1	130.0			6	321.0	9	111.0				
12	Сагил	14	318.2					5	211.0	9	107.2				
13	Тариалан	14	333.3	1	119.8			3	100.0	10	113.5				
14	Түргэн	10	206.4					1	80.0	9	126.4				
15	Тэс	17	399.7					3	224.3	14	175.3				
16	Ховд	10	183.9					1	62.6	9	121.3				
17	Хяргас	14	244.0					3	113.4	11	130.6				
18	Цагаанхайрхан	18	332.0					3	149.8	15	182.2				
19	Улаангом	69	994.7					6	226.4	63	768.3				
	сумын дүн	376	7,214.5	7	760.8	0	0	66	2,893.7	303	3,560.0	0			
1	Увс аймаг ОНХС	32	5,287.2	17	4,658.8			6	291.7	9	336.7				
	нийт дүн	408	12,501.7	24	5,419.7	0	0	72	3,185.4	312	3,896.7	0			

Эх сурвалж: /Аймаг, сумдын ОНХС-ийн нэгтгэл судалгаа/

Тайлант онд аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 14,093.0 сая төгрөгийн 506 төсөл, арга хэмжээнээс 12,501.7 сая төгрөгийн 408 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалт-24
- Харьцуулалтын арга-72
- Шууд худалдан авалт-312

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн, Давст сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх дараах 2 төсөл, арга хэмжээнд оролцогч компаниуд гомдол гаргасан байна.

- ✓ Нийтийн халуун усны байрыг нэгдсэн халаалтын шугамд холбох- 35.0 сая /Бөхмөрөн сум/
- ✓ Сургууль, Цэцэрлэгт ухаалаг самбар авах- 91.0 сая /Давст сум/

Гомдлын дагуу тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт “Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд захиалагчийн гаргасан шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг дараах тохиолдолд түр түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно”, 55.4.1 дэх заалтад “Тендерт оролцогчийн гомдлыг хангах нь илүү үндэслэлтэй байгаа бол” гэж заасныг үндэслэн Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрийн дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- ✓ Бөхмөрөн сумын Нийтийн халуун усны байрыг нэгдсэн халаалтын шугамд холбох 35.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээнд Сангийн яамны 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 03/7119 дүгээр албан бичгээр худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн үнэлгээний хорооны 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн мэдэгдлийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтыг үндэслэн хүчингүй болгож, тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэний дагуу захиалагч оролцогч талуудын тендерийн баримт бичгийг дахин хянаж хамгийн сайн үнэлэгдсэн “Интерренссанс” ХХК-тай гэрээ байгуулсан байна.
- ✓ Давст сумын Сургууль, Цэцэрлэгт ухаалаг самбар авах 91.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнд Сангийн яамны 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 03/7255, 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/9266 дугаар албан бичгүүдээр гомдол үндэслэлтэй гэж үзэн гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг түр түдгэлзүүлсэн тул төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Наранбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ 4 хувааж тендер зарлахгүйгээр 55.5 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэнд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3 дахь хэсэгт “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

Орон нутгийн өмчийн газар ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим сайтад байршуулж, тендерийн урилгыг tender.gov.mn, “Увс Орон нутгийн өмчийн газар” facebook хаяг, UVS.ONUG@G-mail цахим хаяг, МВС телевиз, Увс нам бус телевиз гэсэн орон нутгийн телевиз болон Өглөөний сониноор олон нийтэд мэдээлсэн байна. Мөн 70453262 утсаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны тайланг гаргаж цахимаар болон 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 184 дүгээр албан бичгээр Сангийн яаманд, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 183 дугаар албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байна.

Мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2 дахь хэсэгт “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ” гэсэн заалтын дагуу тендерийн материалыг архивын нэгж болгосон байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөс бодит гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 1 төсөл, арга хэмжээнд 128.0 сая, зориулалт бусаар 2 төсөл, арга хэмжээнд 7.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Увс аймгийн хэмжээнд 2023 онд аймаг, сумдын ОНХС-ийн 14,093.0 сая төгрөгийн эх үүсвэрээр 506 төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр аймаг, сумын ИТХ-аар баталсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 14.

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний				Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
		тоо	дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	Үүнээс дутуу олгосон санхүүжилт		тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	тоо	дүн
								тоо	дүн					
1	Баруунтуруун	20	378.6	18	297.0	15	194.5			3	102.5	90.3	2	74.0
2	Бөхмөрөн	12	284.4	11	233.2	11	233.2						1	45.0
3	Давст	18	344.2	16	251.4	14	239.3			2	12.1	5.5	1	91.0
4	Завхан	22	507.4	20	333.0	19	293.0			1	40.0	3.0	2	41.1
5	Зүүнговь	27	413.3	21	295.6	15	156.0			6	139.6	65.0	6	108.8
6	Зүүнхангай	22	474.9	20	409.8	20	409.8						2	59.5
7	Малчин	36	405.4	34	392.0	33	372.1			1	19.9	10.0	2	10.1
8	Наранбулаг	29	638.5	27	555.4	26	431.6			1	123.8	113.8	2	41.0
9	Өлгийн	17	222.7	16	210.5	14	147.7			2	62.8	30.0	1	9.2
10	Өмнөговь	30	517.6	26	468.2	25	428.4	6	45.6	1	39.8	19.9	4	49.0
11	Өндөрхангай	23	707.0	15	492.3	12	385.4	1	13.2	3	106.9	85.4	7	195.0
12	Сагил	20	388.2	15	288.4	13	263.4			2	25.0	0.0	5	95.0
13	Тариалан	22	435.7	17	335.7	15	210.9			2	124.8	74.9	5	74.1
14	Түргэн	12	231.7	10	197.2	9	117.2			1	80.0	56.0	2	24.3
15	Тэс	20	582.1	19	402.0	17	288.2			2	113.8	90.4	3	154.2
16	Ховд	14	305.5	12	202.3	12	202.3						2	100.0
17	Хяргас	19	300.1	17	248.8	15	198.8			2	50.0	31.4	2	51.0
18	Цагаанхайрхан	29	416.3	24	391.2	19	266.0			5	125.1	77.8	5	17.5
19	Улаангом	78	1073.6	76	1,024.6	75	1,017.6			1	7.0	2.1	2	32.0
	сумын дүн	470	8,627.3	414	7,028.5	379	5,855.4	7	58.8	35	1,173.2	755.4	56	1,271.7
1	Увс аймаг ОНХС	36	5,465.7	35	5,273.7	29	3,311.2			6	1,962.5	477.5	1	100.0
	нийт дүн	506	14,093.0	449	12,302.2	408	9,166.6	7	58.8	41	3,135.6	1,232.9	57	1,371.7

Эх сурвалж: /Аймаг, сумдын ОНХС-ийн нэгтгэл судалгаа/

Тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн 9,166.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 408 төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 9,107.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Харин бүрэн хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээний 58.8 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгоогүй байна. Үүнд:

- ✓ Өвсний нөөц бүрдүүлэх-13.2 сая /Өндөрхангай сум/
- ✓ Урд заалны шал- 5.4 сая /Өмнөговь сум/
- ✓ Ковш худалдан авах-20.0 сая /Өмнөговь сум/
- ✓ Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт- 5.7 сая /Өмнөговь сум/
- ✓ Сургуулийн дотуур байрны засварын зураг- 10.0 сая /Өмнөговь сум/
- ✓ Орлого багийн төвийн дотоод тохижилт-2.5 сая /Өмнөговь сум/
- ✓ Хаваржингийн гар худаг засварлах-2.0 сая /Өмнөговь сум/

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хэрэгжилт дутуу байгаа 2,319.1 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 41 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд нь үндэслэн 2023 онд нийт 1,133.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

Хүснэгт 15.

(сая төгрөг)

№	Сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
1	Баруунтуруун	Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	8.0	7.2
2	Баруунтуруун	Шанд багт гудамжны нарны зайн гэрэлтүүлэг тавих	20.0	16.0
3	Баруунтуруун	Зүүнтурууны голд гүүр барих	74.5	67.1
4	Давст	Малын эрүүл мэндийг хамгаалах	7.8	5.5
5	Давст	ЕБСургууль биеийн тамирын гадна талбай дутуу	4.3	
6	Завхан	Худаг ус засварлах	40.0	3.0
7	Зүүнговь	Жимс жимсгэний жишиг талбай байгуулах ажлын дэд бүтцийг шийдвэрлэх	25.0	5.0
8	Зүүнговь	Авто граж барих ажил	24.0	12.0
9	Зүүнговь	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Хоёр живаа харгаа" төс	13.6	8.0
10	Зүүнговь	Жимс, жимсгэний жишиг талбай хүртэл 0.4 кВ-ын цахилгаан татах	43.0	23.0
11	Зүүнговь	Нуурын хоолойн тохижилт	19.0	9.5
12	Зүүнговь	Ээдний сүвийн ам засавр	15.0	7.5
13	Сагил	Үүрэгнүүр баг Баруун бухад далан шуудуй татах	10.0	
14	Сагил	Сайжруулсан зам хусаж, хог түрэхэд	15.0	
15	Наранбулаг	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах	123.8	113.8
16	Малчин	Баянмандал багийн Улаанбулагийн усны ариг бетондох	19.9	10.0
17	Өлгий	Сургуулийн гадна орчны тохижилт	19.8	10.0
18	Өлгий	Хогийн цэгийг хумих, тор татах	43.0	20.0
19	Өмнөговь	1929, 1933, 1944, 1956 оны хүн амын тооллого бусад түүхэн сурвалжид тулгуурлан Өмнөговь сумын иргэдийн угийн бичгийн эх бэлтгэх	40.0	19.9
20	Тариалан	Тарвагтай, Толь багийн контор, улаан булан барих	114.8	68.9
21	Тариалан	Бургастай багийн Улаан булангийн байрыг засварлах	10.0	6.0
22	Түргэн	сумын төвд гүн өрмийн худаг гаргах	80.0	56.0
23	Тэс	Орон нутаг судлах танхим тохижуулах	16.0	11.2
24	Тэс	Гүүр замын далан засвар	98.0	79.3
25	Өндөрхангай	Сумын төвийн тохижилт	68.0	47.6
26	Өндөрхангай	Шүдний кабинет тохижуулах	28.9	28.1
27	Өндөрхангай	Хүн эмнэлэгийн цэвэр бохир усны шугам засварлах	10.0	9.7
28	Хяргас	Багийн төвийг тохижуулах /Бугат багийн төв/	35.0	17.5
29	Хяргас	Ногоон байгууламж нэмэгдүүлэх арчилах	15.0	14.0
30	Цагаанхайрхан	Сумын өвс,тэжээлийн нөөц бүрдүүлэх	49.6	43.7
31	Цагаанхайрхан	Өнцгийн худгийг засварлах	15.0	3.5
32	Цагаанхайрхан	Мал угаалгын зориулалтын машин авах	51.0	23.0
33	Цагаанхайрхан	Малчдад зориулсан сургалт сурталчилгааны ажил з/б-лах	3.0	2.1
34	Цагаанхайрхан	Малын удмын санг сайжруулах	6.5	5.5
35	Улаангом	Гадна талбайн тоглоом , тохижилт- / 5-р цэцэрлэг /	7.0	2.1
36	Аймаг ОНХС	Улаангом сумын зүүн тойргийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг эхлүүлэх	889.9	250.0
37	Аймаг ОНХС	Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/	256.0	128.0
38	Аймаг ОНХС	Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж /Сагил сум/	99.4	
39	Аймаг ОНХС	Аймгийн Засаг даргын тамгын газрын зураг төсөв /Улаангом сум/	169.0	
40	Аймаг ОНХС	3 дугаар 10 жилийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар - "ТНХ" ХХК- ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл үргэлжлэл /Увс, Улаангом сум/	493.1	
41	Аймаг ОНХС	"Загвар хоршоодын хөгжлийг дэмжих төв" -ийн зөвлөх үйлчилгээ	55.0	
Нийт дүн			3136.0	1133.4

Эх сурвалж: /Аймаг, сумдын ОНХС-ийн нэгтгэл судалгаа/

Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй дээрх төсөл, арга хэмжээнүүдийг гүйцэтгэгч компаниар хийж гүйцэтгүүлэхийг зөвлөмж болголоо.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан 256.0 сая төгрөгийн өртөгтэй “Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/” ажлыг “Аав хад” ХХК-аар 256.0 сая төгрөгөөр 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор гүйцэтгэхээр 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн УВАОНӨГ/202312002 дугаар гэрээг байгуулсан байна.

Гэрээний 5.3.13-д “Урьдчилгаа 30 хувийг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаар, үлдэгдэл санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоно” гэж заасан байх бөгөөд аймгийн Засаг даргын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн А/368 дугаар захирамжаар 76.8 сая, 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/392 дугаар захирамжаар 51.2 сая, нийт 128.0 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 50 хувийг шилжүүлэн өгсөн байна. Аудитын явцад уг ажлын гүйцэтгэлийг хянахад барилгын суурь цутгалтаас өөр ажил хийгдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6-д “ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй”, 4.7.6-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэж заасныг зөрчиж Тариалан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/92 дугаар захирамжаар Тарвагатай багийн иргэний сургалтын төлбөрт гэж 4.0 сая төгрөгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн зөрчилд Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Мөн Хяргас сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумын Эрүүл мэндийн төвийн дотрын их эмчид 3.0 сая төгрөгийн урамшуулал олгосонд Хяргас төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгсөн.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх боломж байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 39 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнд хүрээгүй, 2 төсөл, арга хэмжээ хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг авч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан тусгахаар заасан байна. Үүнээс шалтгаалан аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүх төсөл, арга хэмжээний хувьд зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

Харин зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг тодорхойлох шаардлагатай төсөл, арга хэмжээний хувьд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3 дахь заалтад “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” 14.3 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасан байна.

Аймгийн ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 6 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

Хүснэгт 16.

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Тайлбар
1	Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/	256.0	128.0	Гүйцэтгэгч ажлаа хийж дуусгаагүй. Барилгын суурь цутгасан байдалтай байна. Төсвийг дараа онд шилжүүлсэн.
2	Улаангом сумын зүүн тойргийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг эхлүүлэх	889.9	250.0	Ажил гүйцэтгэх гэрээ 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан гүйцэтгэгч компани нь ажлыг гүйцэтгэж байгаад гадна агаарын температур хүйтэрч дулааны сувгийн цутгалт хийх боломжгүй болсон тул ажлыг зогсоосон. Гүйцэтгэсэн ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж үлдэгдэл санхүүжилт 2024 оны төсөвт суусан.
3	Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж /Сагил сум/	99.4	-	Гүйцэтгэгч ажлаа хийж дуусгаагүй.
4	Аймгийн Засаг даргын тамгын газрын зураг төсөв /Улаангом сум/	169.0	-	Тус ажлын тендер сонгон шалгаруулалт зарлагдаж Дукат ХХК гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 11 сарын 14-ний өдөр гэрээ байгуулсан. Гүйцэтгэх ажлын хэмжээ маш их, олон шат дамжлагатай учраас тухайн онд гүйцэтгэж дуусах боломжгүй тул төсвийг дараа онд шилжүүлсэн.
5	Улаангом сумын Ерөнхий боловсролын 3-р сургуулийн тойргоос-Улиасны хэвийн урд уулзвар -"ТНХ" ХХК- ийн уулзвар-галын 4 зам хүртэлх зүүн тойруугийн явган зам, унадаг дугуйн замын шинэчлэл үргэлжлэл /Увс, Улаангом сум/	493.1	-	Тодотголоор нэмэгдэж. Тендер зарлаж мажестик солюнш рөөд шалгаран тайлан хугацаанд ажлыг гүйцэтгэж чадахгүй болсон тул төсвийг дараа онд шилжүүлсэн.
6	"Загвар хоршоодын хөгжлийг дэмжих төв" -ийн зөвлөх үйлчилгээ	55.0	-	Тодотголоор тус ажил нэмэгдэж тендер сонгон шалгаруулалт 2 удаа зарлагдаж Брэнд гутал ХХК гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 12 сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан. Иймд тухайн онд гүйцэтгэж дуусах боломжгүй тул төсвийг дараа онд шилжүүлсэн.

Эх сурвалж: /Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа/

Дээрх судалгаанд тусгагдсан аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан 256.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн халуун усны барилга, тоног төхөөрөмж /Малчин сум/” ажлыг “Аав хад” ХХК-аар 256.0 сая төгрөгөөр 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор гүйцэтгэхээр 07 дугаар сарын 07-ны өдрийн УВАОНӨГ/202312002 дугаар гэрээг байгуулж аймгийн Засаг даргын 7 дугаар сарын 07-ны өдрийн А/368 дугаар захирамжаар 76.8 сая, 07 дугаар сарын 20-ны өдрийн А/392 дугаар захирамжаар 51.2 сая, нийт 128.0 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 50 хувийг шилжүүлэн өгсөн байна.

Аудитын явцад уг ажлын гүйцэтгэлийг хянахад барилгын суурь цутгалтаас өөр ажил хийгдээгүй байна. Уг асуудлыг тодруулахад сумын Засаг даргын 2024 оны

06 дугаар сарын 11-ний өдрийн 71 дүгээр бичгээр “нийтийн халуун усны барилгын ажлыг 2023 онд гүйцэтгэж дуусгах байсан боловч зөвхөн суурь цутгалтын ажлыг хийсэн. Энэ онд тухайн гүйцэтгэгч компанийн захиралтай холбогдож удаа дараа шаардсан боловч ирж ажлаа эхлүүлэхгүй байна” гэсэн тайлбар өгсөн. Мөн барилгын суурь цутгалтын ажлыг зургийн дагуу хийгээгүй зөрчилд зургийн компанийн зүгээс хяналт хийж зөвлөмж өгсөн байх бөгөөд тухайн компани нь хүний нөөц, мэргэжлийн ажилтны чадавхгүй компани байна гэж орон нутгийн зүгээс дүгнэж цаашид хийгдэх барилгын ажлыг чанаргүй болохоос сэргийлж гэрээгээ цуцлах талаар саналыг аймгийн Засаг даргад сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 67 дугаар бичгээр хүргүүлсэн байна.

Мөн аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 262 дугаар бичгээр “Аав хад” ХХК нь тухайн ажлыг 2023 ондоо багтаан гүйцэтгэж хүлээлгэн өгөх байсан боловч өнөөдрийг хүртэл гүйцэтгээгүй байна. Одоогийн байдлаар барилгын шугаман суурийн ажил гүйцэтгэсэн байдалтай байгаа бөгөөд гүйцэтгэгч компанид удаа дараа ажлаа хийж гүйцэтгэхийг шаардсан боловч хийж гүйцэтгэхгүй байна гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Тухайн ажлыг бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийн 50 хувийг олгосон, ажил нь хийгдэхгүй он дамжиж байгаа асуудлыг Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ” гэж заасны дагуу шалгуулах саналтайгаар ашиглагч байгууллагын эрх бүхий албан тушаалтны тайлбар болон холбогдох бусад баримтыг Үндэсний аудитын газарт Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 264 дүгээр албан бичгээр хүргүүлэв.



Сумдын ОНХС-аас хийгдсэн хэрэгжилт дутуу 35 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

Хүснэгт 17.

(сая төгрөг)

Д/д	Сумдын нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Тайлбар
1	Баруунтуруун	3	102.5	90.3	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
2	Давст	2	12.1	5.5	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж он дамжихаар болсон 2 ажил, гүйцэтгэгч ажлаа хийгээгүй 1 ажил байна
3	Завхан	1	40.0	3.0	Төндөр худалдан авах ажиллагаа зохион байгуулалттай холбоотойгоор хүйтэрч он дамжин хийгдэхээр болсон
4	Зүүнговь	6	139.6	65.0	Тухайн тендерүүд эрт зарласан хэдий оролцогч орж ирэхгүй байсаар гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж он дамжихаар болсон

5	Малчин	1	19.9	10.0	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
6	Наранбулаг	1	123.8	113.8	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
7	Өлгийн	2	62.8	30.0	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
8	Өмнөговь	1	39.8	19.9	Судалгааны ажил нь дуусаагүй байна
9	Өндөрхангай	3	106.9	85.4	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
10	Сагил	2	25.0	-	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
11	Тариалан	2	124.8	74.9	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
12	Түргэн	1	80.0	56.0	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
13	Тэс	2	113.8	90.4	Гүйцэтгэгч ажлаа хийж дуусгаагүй тул он дамжин хийгдэхээр байна
13	Хяргас	2	50.0	31.4	Бугат багийн төвийн тохижилт 35.0 сая төгрөгийн ажлыг цахимаар 8 удаа зарлаад сүүлийн тендер шалгаруулалт 10 сарын 25 нд шалгарсан тул гэрээ хийгдэж материал татаж санхүүжилт 50 хувь олгогдсон байна. Ногоон байгууламжийн ажил гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
14	Цагаанхайрхан	5	125.1	77.8	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
15	Улаангом	1	7.0	2.1	Гэрээ оройтож байгуулснаас шалтгаалж хүйтэрч он дамжихаар болсон
	Нийт	35			

Эх сурвалж: /Сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа/

Дээрх судалгаанд тусгагдсан Давст сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан Биеийн тамирын гадна талбай тохижуулах 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Ренчинсуурь” ХХК 42.8 сая төгрөгөөр 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор гүйцэтгэхээр 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дугаар №УВДСЗДТГ/2022/05/03 гэрээг байгуулж сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн А/58 дугаар захирамжаар 21.4 сая, 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/74 дүгээр захирамжаар 17.1 сая, нийт 38.5 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 90 хувийг шилжүүлэн өгсөн байна. Мөн 2023 онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээс үлдэгдэл санхүүжилт 4.3 сая төгрөгийг олгохоор тусгасан байна.

2023 онд хийсэн санхүүгийн тайлангийн завсрын аудитын явцад “сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 61 дүгээр албан бичгээр манай сургуулийн гадна биеийн тамирын талбай ОНХС-аас 45.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр тендерт “Ренчинсуурь” ХХК шалгарсан. Ажлын гүйцэтгэл нь сагс, гар бөмбөгийн талбайн цутгалт цементэн талбай хийгдсэн. Бусад ажлууд нь хийгдээгүй байна. Ажлын гүйцэтгэлийг хийлгэхээр уг компанитай холбогдоход утсаа аваагүй, тендерт ирүүлсэн хаягаар очиход хаягийн шинэчлэл хийгдсэнтэй холбоотой уг хаяг дээр байхгүй байгаа зэрэг асуудлууд гарч байна” гэсэн тайлбар өгсөн бөгөөд аудитын явцад дахин тодруулахад уг ажлын гүйцэтгэл явагдахгүй, гүйцэтгэгч компани олдохгүй байгаа тул шалгуулах хүсэлтийг манай байгууллагад Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Тухайн ажлыг бүрэн хийгдээгүй байхад ажлын гүйцэтгэлийг 90 хувь гэж гарган санхүүжилт олгосон, ажил нь огт хийгдээгүй 2 жил дамжсан асуудлыг Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт

бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ” гэж заасны дагуу тус асуудлыг Үндэсний аудитын газарт Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 264 дүгээр албан бичгээр хүргүүлэв.



2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр, үр нөлөө багатай байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1.4-д “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэж заасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэт жижиглэн олон төсөл, арга хэмжээ тусгасан байна.

Хүснэгт 18.

(сая төгрөг)

Д/д	Аймаг, сумууд	Нийт санхүүжилт	Төлөвлөсөн ажлын тоо	Нэг ажилд ногдох дундаж санхүүжилт
1	Аймаг	5,465.7	36	151.8
2	Баруунтуруун	378.6	20	18.9
3	Бөхмөрөн	284.4	12	23.7
4	Давст	344.3	18	20.3
5	Завхан	507.4	22	23.1
6	Зүүнговь	413.3	27	15.3
7	Зүүнхангай	474.9	22	21.6
8	Малчин	405.4	36	11.3
9	Наранбулаг	638.5	29	22.0
10	Өлгий	222.7	17	13.1
11	Өмнөговь	517.6	30	17.3
12	Өндөрхангай	707.0	23	30.7
13	Сагил	388.2	20	19.4
14	Тариалан	435.7	22	19.8
15	Түргэн	231.7	12	19.3
16	Тэс	582.1	20	29.1
17	Ховд	305.5	14	21.8
18	Хяргас	300.1	19	15.8
19	Цагаанхайрхан	416.3	29	14.4
20	Улаангом	1,073.6	78	13.7
	Нийт дундаж	14,093.0	506	27.9

Эх сурвалж: /Аймаг, сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн нэгтгэсэн судалгаа/

Хүснэгтээс харахад аймаг, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээнд дунджаар 27.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж баталсан байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл,

арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн иргэдийн саналыг авсан байхаар хууль, журамд зохицуулсан байдаг бөгөөд тухайн орон нутгийн иргэд нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго, үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан өөрийн эрх ашигт хамааралтай жижиг ажлыг тусгуулах санал өгдөг, мөн аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүр тойрог, тойрогтоо ОНХС-аас хөрөнгө хуваарилуулах зорилгоор төсөл, арга хэмжээг хэт жижиглэж байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилгыг хангахгүй байх, бодит үр дүн, үр нөлөө багатай ажлууд төлөвлөгдөж хэрэгждэг асуудал жил бүр давтагдаж байна. Тухайлбал: 2023 онд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс 1.7 сая төгрөгийн, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээс 1.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа нь “Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэсэн ОНХС-ийн зорилгод нийцэхгүй байна.

Эндээс дүгнэхэд ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгагдсан томоохон хэмжээний төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж чадахгүй байна.

Ялангуяа холбогдох чиг үүрэг бүхий агентлаг, тухайн төсөвт байгууллагын төсөвт тусган баталж хэрэгжүүлэхээр, аж ахуйн нэгж, иргэдийг зохион байгуулалтад оруулах замаар шийдвэрлэх боломжтой ажлуудыг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөх шаардлагагүй байна.

Иймд хууль эрх зүйн орчныг оновчтой болгох, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд санал өгч байгаа анхан шатны нэгж болох ард иргэдийг мэдлэг, мэдээллээр хангах замаар орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц томоохон төсөл, арга хэмжээг зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодит тооцоо судалгаанд үндэслэн нарийвчлан тооцож төлөвлөн баталснаар гарах үр дүн, үр ашгийг бодиттойгоор дээшлүүлэх боломжтой гэж үзэж Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

Харин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээнүүд иргэдийн амьдрах таатай орчин бүрдэх, орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлэхээр байна. Үүнд:

- Улаангом сумын зүүн тойргийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг эхлүүлэх - 250.0 сая,
- Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг /Улаангом сум, 10 дугаар баг/ - 150.0 сая,
- Гэр хорооллын гэрэлтүүлэг /Улаангом сум, 1 дүгээр баг/- 233.9 сая,
- 7-р багийн гэрэлтүүлгийн засвар, шинэчлэл /Улаангом/- 93.5 сая,
- Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил /Улаангом сум/ - 595.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнүүд байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд бүрэн хэрэгжүүлсэн 9,166.6 сая төгрөгийн 408 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүдийг тухайн ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгасан

байх бөгөөд ашиглалт хэвийн байна.

Хөрөнгийн ашиглалт, үр дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 19.

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд				ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт								ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ		
		тоо	гэрээний дүн	хүрсэн TAX		хүрээгүй TAX		Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй TAX		Зориулалтын бус ашиглаж буй TAX		Огт ашиглаагүй TAX		TAX-ний тоо /Сайн/	TAX-ний тоо /Дунд/	TAX-ний тоо /Хангалтгүй/		
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн				тоо	дүн
1	Баруунтуруун	15	194.5	15	194.5			15	194.5					15				
2	Бөхмөрөн	11	233.2	11	233.2			11	233.2					11				
3	Давст	15	239.3	15	239.3			15	239.3					14				
4	Завхан	19	293.0	19	293.0			19	293.0					19				
5	Зүүнговь	15	156.0	15	156.0			15	156.0					15				
6	Зүүнхангай	20	409.8	20	409.8			20	409.8					20				
7	Малчин	33	372.1	33	372.1			33	372.1					33				
8	Наранбулаг	25	431.6	25	431.6			25	431.6					26				
9	Өлгий	14	147.7	14	147.7			14	147.7					14				
10	Өмнөговь	25	428.4	25	428.4			25	428.4					25				
11	Өндөрхангай	13	385.4	13	385.4			13	385.4					13				
12	Сагил	13	263.4	13	263.4			13	263.4					12	1			
13	Тариалан	15	210.9	15	210.9			15	210.9					15				
14	Түргэн	9	117.2	9	117.2			9	117.2					9				
15	Тэс	16	288.2	16	288.2			16	288.2					16				
16	Ховд	12	202.3	12	202.3			12	202.3					12				
17	Хяргас	15	198.8	15	198.8			15	198.8					15				
18	Цагаанхайрхан	19	266.0	19	266.0			19	266.0					19				
19	Улаангом	75	1017.6	75	1,017.6			75	1017.6					75				
	сумын дүн	379	5855.4	379	5,855.4	0	-	379	5,855.4					378	1			
1	Увс аймаг ОНХС	29	3,311.2	29	3,311.2			29	3,311.2					29				
	нийт дүн	408	9,166.6	408	9,166.6	0	-	408	9,166.6			0	-	407	1	0		

Эх сурвалж: /аймаг сумдын ОНХС-ийн нэгтгэсэн судалгаа/

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд хийсэн зарим онцлог ажлуудаас дурдахад:

- ✓ Бөхмөрөн сумын нийтийн халуун усны байрыг нэгдсэн халаалтын шугамд холбосноор иргэд тав тухтай дулаан орчин үйлчилгээ авах боломж бүрдсэн,
- ✓ Завхан сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг шүд эрүүлжүүлэх хөтөлбөрт хамруулсан нь эцэг эх иргэдээс талархал хүлээсэн,
- ✓ Наранбулаг сумын Гэр хорооллын 04 кВт.ц цахилгаан дамжуулах шугамын шинэчлэл, гэрэлтүүлгийн ажил хийгдсэнээр иргэдийн амьдрах орчин сайжирсан,
- ✓ Өмнөговь сумын сургуулийн дотуур байрны ногооны зоорийг шинэчилсэн нь хүүхдийн хоолны материалын хадгалалт хамгаалалт сайжирсан,
- ✓ Сагил сумын хилийн заставуудын хамгаалалтын тор, хяналтын камер тоног төхөөрөмжийг шинэчилснээр малын хулгайн гэмт хэрэг багасах боломж бүрдсэн,
- ✓ Тэс сумын Төв зам дагуу ногоон байгууламж хайсан хашаа услалтын систем хийснээр сумын өнгө үзэмж нэмэгдэж, ая тухтай орчин бүрдсэн,
- ✓ Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвд шүдний шаардлага хангасан чанартай тоног төхөөрөмж нийлүүлснээр иргэд цаг алдалгүй үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн, мөн 2 багт худгийг жишиг худаг болгож засварласан нь иргэдийн ундны усны чанар хүртээмж дээшилсэн,
- ✓ Улаангом сумын нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй барьсан авто гараашнуудыг буулгах ажил хийгдсэнээр орчны тохижилт сайжирсан, ухаалаг худгуудад ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулснаар 3000 гаруй айл өрх эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангагдах боломж бүрдсэн зэрэг бодит үр дүнд хүрсэн, ашиглалт нь хэвийн явагдаж байгаа сайн жишээ байна.

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Өмнөговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 119.5 сая төгрөгийн өртөгтэй Ковш тракторыг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/171 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн №1 дүгээр хүлээн авах акт үйлдэж Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд тусгасан байна. Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/190 дүгээр захирамжаар 100.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Гэтэл тухайн ковш нь Өмнөговь суманд биетээр байхгүй байсан бөгөөд хүлээж авах үед асахгүй байсан учир 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гэхэд хүлээлгэн өгөх нэмэлт гэрээг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулж тухайн ковш тракторыг бэлтгэн нийлүүлэгчид буцаасан гэсэн тайлбар өгсөнд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3 дахь хэсэгт “Жинхэнэ хэрэгжилтийн” гэж заасны дагуу биетээр байхгүй данс бүртгэлд тусгасан үндсэн хөрөнгийг техникийн нөхцөлд заасан шаардлагын дагуу хүлээн авах зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулсан.

БҮЛЭГ 3

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН ТАЙЛАГНААГҮЙ,
ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна.

3.1.1. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, аймаг, сумдын ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 64.1.1 дэх хэсэгт “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих”, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг”, 3.2.2-д “Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/12 дугаар захирамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Улаангом суманд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын явц байдалтай газар дээр нь танилцах, ажлын гүйцэтгэлд хяналт хийх, үйл ажиллагааг нь эрчимжүүлэн ажиллах болон орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хянах зорилгоор хяналтын ажлын хэсгийг байгуулан 595.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажилд мэргэжлийн чиг үүрэгтэй байгууллагын албан хаагчдыг оролцуулан явцын хяналт хийсэн байна.

Сагил, Улаангом, Тариалан, Зүүнговь, Өмнөговь, Өндөрхангай сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Харин бусад сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хяналт шалгалт хийснийг нотлох баримт материал байхгүй байна.

Цаашид хууль журамд тусгагдсан хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байхыг зөвлөлөө.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10 дахь заалтад “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч дотоод аудиттай байх талаар болон дотоод аудитын чиг үүргийг тусгажээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Түргэн, Өлгий, Цагаанхайрхан, Баруунтуруун сумдын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын хүрээнд ОНХС-ийн 2023 оны зарцуулалтад хяналт хийж илэрсэн зөрчилд зөвлөмж чиглэл өгсөн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар

батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Харин сумдын 2023 оны ажлыг дүгнэхдээ ОНХС-ийн хэрэгжилтийг нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна.

Цаашид ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст зөвлөв.

3.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар гэрээний дагуу хэрэгжүүлж байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.4 дэх заалтад “Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.4 дэх заалтад “Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 37.1.9 дэх заалтад “Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах” гэж заажээ.

Мөн тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-д “Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, 5.2.2 дахь заалтад “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4-т “Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2023 дугаар “Аймагт

хэрэгжүүлэх барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулан ажилласан байна.

Уг гэрээнд заасны дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн томоохон төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үе шатны ажил болгон дээр хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж, чиглэл өгч ажиллажээ. Мөн төсөл, арга хэмжээнүүдэд аймгийн Засаг даргын улсын комисс ажиллуулах захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд сумын Засаг даргын захирамж болон ашиглагч байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг захиалагчийн хяналтыг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтой нийцүүлэн тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.1.3. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 20.

№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн Хувь
1	Орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлахгүй байх	100%
2	Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 26 төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх	100%
3	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7.6 дахь заалтыг мөрдөж ажиллах	100%
4	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах	100%
5	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Шинэ хөдөө" төслийн хүрээнд дэмжлэг хэлбэрээр 9.8 сая төгрөгийн улаан хальст сармисны үрийг Хүнс хөдөө аж ахуйн газрын дансанд авлага тусгах	100%
6	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тоо хэмжээ, нэр төрлийг тодорхой тусган боловсруулж байх	100%
7	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах	100%
Биелэлтийн дундаж хувь		100%

Аймаг, сумдын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт дараах байдалтай байна.

№	Зөрчил шийдвэрлэлтийн утга	Биелэлтийн Хувь
1	Өмнөговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 5 ажлын 43.6 сая төгрөгийн дутуу санхүүжилтийг өглөгөөр тусгаагүйд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр" гэж заасныг мөрдөж өр төлбөрийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах зөвлөмж өгсөн.	100%
2	Өмнөговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 119.5 сая төгрөгийн өртөгтэй Ковш тракторыг сумын	100%

	Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/171 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн №1 дүгээр хүлээн авах акт үйлдэж Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд тусгасан байна. Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/190 дүгээр санхүүжилт олгох захирамжаар 23-ны өдөр 100.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Гэтэл тухайн ковш нь хүлээж авах үед асахгүй байсан учир 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гэхэд хүлээлгэн өгөх нэмэлт гэрээг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулж буцаасан байна. Тухайн хөрөнгө Өмнөговь суманд биетээр байхгүй байсанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3 дахь хэсэгт "Жинхэнэ хэрэгжилтийн" гэж заасны дагуу биетээр байхгүй данс бүртгэлд тусгасан үндсэн хөрөнгийг техникийн нөхцөлд заасан шаардлагын дагуу хүлээн авах зөвлөмж өгсөн.	
3	Өмнөговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс тендерийн бичиг хэргийн материал худалдан авсан 0.1 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүйд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6 дахь заалтад "Бүх зардал" гэж заасныг мөрдөж зардлыг санхүүгийн тайланд бүрэн тусгах зөвлөмж өгсөн.	Хугацаа болоогүй
4	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдсэн 40.0 сая төгрөгийн Дүк машин, 29.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, 7.9 сая төгрөгийн Өндөрмод багийн төвийн тохижилт, засварын ажил, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр худалдан авсан 1.0 сая төгрөгийн принтер, нийт 77.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүйд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь заалтад "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг мөрдөж үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах зөвлөмж өгсөн.	100%
5	Завхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийг батлуулахдаа төсөл, хөтөлбөргүй 17.4 сая төгрөгийн 4 ажлыг батлуулж санхүүжүүлсэнд "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн дагуу хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ажилд хөтөлбөр, төсөл боловсруулан эдийн засгийн үндэслэлийг тусган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах зөвлөмж өгсөн.	100%
6	Тариалан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Тарвагатай багийн иргэний сургалтын төлбөрт 4.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.	100%
7	Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийг батлуулахдаа төсөл, хөтөлбөргүй 50.0 сая төгрөгийн 3 ажлыг батлуулж 49.7 сая төгрөгийн санхүүжилт олгосонд "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн дагуу хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ажилд хөтөлбөр, төсөл боловсруулан эдийн засгийн үндэслэлийг тусган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах зөвлөмж өгсөн.	100%
8	Хяргас сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумын Эрүүл мэндийн төвийн дотрын их эмчид 3.0 сая төгрөгийн урамшуулал олгосонд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгсөн.	Хугацаа болоогүй
9	Наранбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөс Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолоор Хурлын төлөөлөгчдийг чадавхжуулахад 5.8 сая, багийн засаг дарга нарын үйл ажиллагааг дэмжихэд 2.0 сая, нийт 7.8 сая төгрөгийн арга хэмжээг баталж зарцуулсанд албан шаардлага өгсөн.	Хугацаа болоогүй

10	Наранбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өвс тэжээлийн нөөц бэлтгэхдээ 4 хувааж тендер зарлахгүйгээр 55.5 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3 дахь хэсэгт “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.	Хугацаа болоогүй
11	Тэс сумын ОНХС-ийн эх үүсвэрээс Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдаагүй Нэгдүгээр сургуулийн ухаалаг самбар авах ажилд 25.9 сая төгрөг зарцуулсанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталж байх зөвлөмж өгсөн.	100%
Биелэлтийн дундаж хувь		

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаагүй, удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-д “Сум дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана”, журмын 9.9-д “Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана” гэж заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг нэгтгэж хүргүүлээгүй байна.

Журамд заасны дагуу ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

Мөн журмын 9.11-т ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ” гэж заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнасан байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан ч 1 төсөл, арга хэмжээг буруу дүнгээр бүртгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

Наранбулаг сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолоор Цэцэрлэгийн засварын ажлыг сумын ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталж 20.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Уг ажилд аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 14/01 дүгээр тогтоолоор Орон нутгийн төсвийн хөрөнгө хөрөнгө оруулалтаар 80.0 сая төгрөг батлагдсан байх бөгөөд сумын ОНХС-ын эх үүсвэрээс 20.0 сая төгрөгийг нэмж, нийт 98.6 сая төгрөгийн тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Тухайн ажлыг хүлээн авч данс бүртгэлд тусгахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.3.2 дахь заалтад “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “үнэн зөв байх” гэж заасныг зөрчиж сумын ОНХС-ийн санхүүжилт болох 20.0 сая төгрөгийг оруулахгүйгээр орон нутгийн хөрөнгө оруулалтын 78.6 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна. Тухайн хөрөнгийг бодит өртгөөр нь данс бүртгэлд тусгахыг зөвлөмж болгов.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон бусад үндсэн хөрөнгийг тухайн ашиглагч байгууллагын дансанд бүртгэж тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчин Сагил, Өндөрхангай сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчилд сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгч данс бүртгэлд тусгуулсан. Үүнд:

- Сагил сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдсэн 40.0 сая төгрөгийн Дүк машин, 29.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, 7.9 сая төгрөгийн Өндөрмод багийн төвийн тохижилт, засварын ажил нийт 76.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Өндөрхангай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 80.9 сая төгрөгийн өвс тэжээлийг данс бүртгэлд тусгаагүй.

3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалтад, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд 5 сум оруулаагүй, 11 сум дутуу оруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “ил тод байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх

зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ” Үүнд:

- 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;
- 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;
- 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;
- 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаа дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх гэж заасан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2-д “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ”, 10.2.1-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна” гэж заасан байна.

Аудитын явцад Сангийн яамны ОНХС-ийн мэдээллийн <https://onhs.mof.gov.mn/> цахим системд оруулсан мэдээллийг хянаж үзэхэд Түргэн, Хяргас, Наранбулаг, Сагил, Тэс сумууд мэдээллийг оруулаагүй, Зүүнговь, Зүүнхангай, Өмнөговь, Өндөрхангай, Цагаанхайрхан, Баруунтуруун, Улаангом сумд болон аймгийн ОНХС-ийн мэдээллийг дутуу оруулсан байна. Үүнд:

Хүснэгт 21.

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	Баруунтуруун	20	378.6			16	329.4	4	49.2
2	Бөхмөрөн	12	284.4	9	201.2	2	38.2	1	45.0
3	Давст	18	344.2	15	230.4	1	7.8	2	106.0
4	Завхан	22	507.3	21	460.2			1	47.1
5	Зүүнговь	27	413.3	13	138.4	14	274.9		
6	Зүүнхангай	22	474.9	9	193.4	13	281.5		
7	Малчин	36	405.9	36	405.9				
8	Наранбулаг	29	638.5					29	638.5
9	Өлгий	17	222.6	16	179.1			1	43.5
10	Өмнөговь	30	517.6	9	126.9	10	224.6	11	166.1
11	Өндөрхангай	23	707.0	19	627.0	1	29.0	3	51.0
12	Сагил	20	388.2	0	-	1	30.0	19	358.2
13	Тариалан	22	435.7	22	435.7				
14	Түргэн	12	231.7	0		0		12	231.7
15	Тэс	20	582.1					20	582.1
16	Ховд	14	305.5	12	283.9	2	21.6	0	
17	Хяргас	19	300.0	0		0		19	300.0
18	Цагаанхайрхан	29	416.2			18	284.2	11	132.0
19	Улаангом	78	1,073.6	70	998.1	8	75.5		
	Сумын дүн	470	8,627.3	251	4,280.2	86	1,596.7	133	2,750.5
1	Аймгийн ОНХС	36	5,465.7	25	3,049.7	10	2,316.0	1	100.0
	нийт дүн	506	14,093.0	276	7,329.9	96	3,912.6	134	2,850.5

Эх сурвалж: /Сумдын судалгаа, Сангийн яамны цахим систем/

Журмын 10.2.3-д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна”, 10.2.5 -д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ”, 10.3-д “Тухайн орон нутгийн төрийн сангийн төлбөр тооцоо, зарлага хариуцсан мэргэжилтэн нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ ОНХС-ийн УМС-ийг дараах байдлаар ашиглана” гэж заасан байхад аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсээс ОНХС-ийн УМС-д мэдээлэл оруулаагүй байна.

Цаашид аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын Засаг даргын тамгын газар Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд журамд заагдсан мэдээллийг оруулж, ашиглалтыг сайжруулж ажиллахыг зөвлөлөө.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно гэж заасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр мэдээлсэн байна. Мөн байгууллагын мэдээллийн самбарт мэдээллийг байршуулжээ.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Бөхмөрөн, Наранбулаг сум иргэдээс санал аваагүй байна.
3. ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 41 төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байна.
4. “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлээгүй байна.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 78.6 сая, сумын ОНХС-ын эх үүсвэрээс 20.0 сая, нийт 98.6 сая төгрөгийн өртөгтэй Наранбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн засварын ажлыг 78.6 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна.
6. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хэрэгжүүлж байна.

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналд дараах хариуг хүргүүлж байна.

1. Аймгийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 410 дугаар бичгээр тайлангийн төсөлд 4 санал ирүүлсэн байна. Үүнд:
 - “Төрийн аудитын газарт явуулсан саналын үр дүнг тайланд оруулах”. Төрийн аудитын газарт явуулсан саналын үр дүн гарахад тодорхой хугацаа шаардлагатай байдаг тул тайланд тусгах боломжгүй болно.
 - “Аймгийн аудитын газрын акт, зөвлөмж, үүрэг даалгаварын биелэлт болон үр дүнг тусгахдаа үндсэн баримтыг хавсаргах”. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг үр дүнг тайланд тусгасан бөгөөд баримтжуулалт нь архивын баримтад нэгтгэгддэг болно.
 - “Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч компаниудын судалгааг сүүлийн 5-10 жилээр гаргах, гэрээ сунгагдсанаас болон хугацаандаа хийгээгүйгээс гарсан илүү зардлыг тооцоолох. Шаардлагатай тохиолдолд хар дансанд оруулах”. Энэ төрлийн зөрчлийг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд жил бүр аудит хийхдээ тухайн үед нь шийдвэрлэн тайланд тусгаж холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.
 - Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, төсвийн захирагчид хариуцлага тооцох. Тайланд тусгагдсан зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн жилийн эцсийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрлэн хүргүүлсэн болно.
2. “Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 1/1305 дугаар албан бичигт “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно” гэсэн байна.
3. “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 288 дугаар албан бичигт “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан хүргүүлэх саналгүй байна” гэсэн байна.
4. “Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 42 дугаар албан бичигт “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх сөнөл байхгүй болно” гэсэн байна.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Бөхмөрөн, Наранбулаг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

- Орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлахгүй байх.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргад:

- ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлж ажиллах.

Аймгийн Засаг дарга, сумдын засаг дарга нарт:

- Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 41 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх.

Наранбулаг сумын Засаг даргад:

- Хүүхдийн цэцэрлэгийн засварын ажлыг бодит өртгөөр нь данс бүртгэлд тусгах.

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

- Орон нутгийн иргэд нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго, үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан өөрийн эрх ашигт хамааралтай жижиг ажлыг тусгуулах санал өгдөг, мөн аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүр тойрог, тойрогтоо ОНХС-аас хөрөнгө хуваарилуулах зорилгоор төсөл, арга хэмжээг хэт жижиглэж байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн зорилгыг хангахгүй байх, бодит үр дүн, үр нөлөө багатай ажлууд төлөвлөгдөн хэрэгждэг асуудал жил бүр давтагдаж байгааг хууль, журамд өөрчлөлт оруулах асуудлыг нэгдсэн тайланд тусгах.
- Сумдад олгохоор төлөвлөсөн санхүүжилт Сангийн яамнаас 151.8 сая төгрөгөөр дутуу ирснээс шалтгаалан сум бүрд тодорхой хэмжээгээр бууруулан хуваарилж олгосон байна. Тухайн жилийн Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар холбогдох албан тушаалтанд чиглэл хүргүүлэхийг нэгдсэн тайланд тусгах.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Т.НАМЖИЛ
Т.АМАРМЭНД
Б.НЯМБУУ